



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн 75,000,000.00 (далан таван сая) төгрөгийн балансын үнэ, 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Төрийн аудитын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний аудитын газрын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бундхорол, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 21 өдрийн
187 дугаар тогтоолын хавсралт



Дорнод аймгийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Дорнод аймгийн Төрийн аудитын
газарт эзэмшүүлж, бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/А шиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элдэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	"Прадо 150" маркийн улсын дугаар 00-06 ДОА, арлын дугаар TRJ1500020725	2011/2019	1	75,000,000.00	15,000,000.00	60,000,000.00
	Нийт дүн			75,000,000.00	15,000,000.00	60,000,000.00
				(далан таван сая)	(арван таван сая)	(жаран сая)